

## Аялал жуулчлалаар дамжуулан Монгол Улс болон Өвөр Монголын иргэдийн ойлголцлыг гүнзгийрүүлэх тухайд<sup>1\*</sup>

**Мао Яньли**

*БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөгжлийн судалгааны төв.*

*Хятад, Монгол, Оросын хамтын ажиллагааны хүрээлэн, судлаач Ph.D*

*Цахим хаяг: [1915795638@qq.com](mailto:1915795638@qq.com)*

**Хураангуй:** Монгол, Хятадын соёл нь танин мэдэхүйн хүрээнд ялгаатай ба нийтлэг шинжтэйг бид бүхэн мэднэ. Өвөр Монголын Өөртөө Засах Орон /ӨМӨЗО/ нь Хятад, Монголын соёлын солилцоонд гүүр болох үүднээс сүүлийн жилүүдэд Монгол Улстай боловсрол, эмчилгээ, аялал жуулчлал, урлаг уран сайхан зэрэг соёлын солилцооны олон чиглэлээр хамтран ажиллаж байгаа бөгөөд үүнээс аялал жуулчлалын хамтын ажиллагаа гол чиглэл болно. Иймээс энэ өгүүлэлдээ санал асуулга, кейс судалгаа, холбогдох ном зохиолыг уншиж судлах аргыг хэрэглэн Монгол Улс болон Өвөр Монголын ард иргэдийн харилцан зорчин аялж байгаа өнөөгийн нөхцөл байдлаас тодорхой ойлголт авч, оршин буй асуудлуудыг судалж, цаашид хэрэгжүүлэх холбогдох арга хэмжээг санал болгож байна. Монгол Улс болон Өвөр Монголын хооронд аялал жуулчлалын хамтын ажиллагааны орчныг эвтэй найртай, зохистой аргаар бий болгосноор жирийн иргэдийн харилцан зорчих эрэлт хэрэгцээг бодитоор хангаж, аялал жуулчлалын хамтын ажиллагаагаар хоёр талын иргэд хоорондын харилцааг ахиулах, харилцан итгэлцлийг дэмжиж, эцэст нь хоёр орны жирийн ард иргэдийн ойлголцлыг буй болгохыг зорьсон болно. Чингэснээр Монгол, Хятад хоёр орны хамтын ажиллагааг хөгжүүлэх нийгэм олон нийтийн хүсэл сонирхлын бат бөх суурийг тавьж өгөх юм.

**Түлхүүр үгс:** Монгол Улс, Өвөр Монгол иргэд хоорондын харилцан аялах хүсэл сонирхол

---

1 “Энэхүү судалгааг “Монгол Улсын иргэд Өвөр Монголд жуулчлах тухай санал асуулга” ба “Өвөр Монголын иргэд Монгол Улсад жуулчлах тухай санал асуулга” дээр үндэслэн хийв. “Монгол Улсын иргэд Өвөр Монголд аялах иргэний санал асуулга” цаасан суурьтай, хүчин төгөлдөр санал асуулга 493 хуудас: “ӨМӨЗО-ны иргэд Монгол Улсад аялах иргэний санал асуулга” цахим, хүчин төгөлдөр санал асуулга 482ш.

1994 оноос эхлэн, Монгол Улс, БНХАУ-ын хооронд “Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ”-г байгуулж, улмаар гурван жил тутамд төлөвлөгөөг бодитоор хэрэгжүүлж ирлээ. 2014 онд БНХАУ-ын ГХЯ-аас зарласан “БНХАУ болон Монгол Улсын найрсаг солилцооны жилийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хөтөлбөр”-г хүмүүнлэгийн салбарын 22 төрлийн үйл ажиллагааг хамруулсан байна<sup>2</sup>. БНХАУ-ын Ши Жиньпин дарга: “Соёлын болон хүмүүнлэгийн солилцоог эрчимжүүлж, ард түмний найрсаг сэтгэлийг байнга дээшлүүлнэ. Ашиг хонжоо харж нөхөрлөвөл ашиг хонжоо нь дуусахад нөхөрлөл ч дуусна. Эрх ашгийг харж нөхөрлөсөн бол эрх ашиг нь алдагдахад нөхөрлөл ч сүйрэх болно. Гагцхүү анд нөхрийн сэтгэлээр ханилах нь өнө удаан настай. Улс гүрний харилцааны хөгжил нь эцэстээ иргэдийн сэтгэл зүрхээр нийлнэ”<sup>3</sup> гэжээ. Энэ нь иргэд хоорондын ойлголцол бол “Бүс ба Зам”-ын бүтээн байгуулалтын үндсэн нийгмийн суурь үндэс болохыг харуулж байна. 2018 оны 4 дүгээр сард, Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх БНХАУ-д айлчлах үеэрээ “Ард иргэдийн найрсаг харилцаа, хүмүүнлэгийн хамтын ажиллагааг идэвхтэй өрнүүлэх нь хоёр улсын харилцааны нийгмийн үндсийг бэхжүүлэх, хоёр ард түмний харилцан ойлголцол, найрамдал нөхөрлөлийг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой”

гэж онцлоод мөн “Монгол Улс БНХАУ-ын “Бүс ба зам” санаачлагын хүрээн дэх соёл, хүмүүнлэгийн харилцаа, хамтын ажиллагаанд нэгдсэн бодлогоор идэвхтэй оролцож, БНХАУ-ын болон “Бүс ба зам” дагуух улс орнуудын ард түмэнд эх орноо сурталчлан таниулахыг хүсэж байна”<sup>4</sup> гэж тэмдэглэжээ. Соёл хүмүүнлэгийн солилцоонд аялал жуулчлалын хамтын ажиллагаа нь хоорондын зайг ойртуулж, хүмүүсийн харилцааг ахиулах чухал хэлбэр болно. Эрүүл саруул жуулчлалыг хөгжүүлэх нь эдийн засгийн өсөлтийн цэг төдийгүй соёлын харилцааны чухал арга зам юм. Монгол Улс болон Өвөр Монгол нь уул усаараа холбогдсон, Монгол Улсын иргэд болон өвөрмонголчууд хоорондоо хэл нэвтэрдэг, зан заншил ижил төстэй, үндэснийхээ соёлыг нэлээд өндөр түвшинд хүлээн зөвшөөрдөг зэрэг хүмүүнлэгийн салбар дахь хамтын ажиллагааны өвөрмөц давуу талтай бөгөөд харилцан аялал жуулчлалыг хөгжүүлэх асар их нөөцтэй. Товчхон хэлэхэд, Монгол Улс, Өвөр Монголын бүс нутаг нь иргэдийн харилцан аялах замаар бий болсон эдийн засгийн үр өгөөжийг хуваалцахын зэрэгцээ үүнээс үүссэн нийгмийн үр нөлөө, иргэдийн үндсэн байдал, аяллын дадал зуршил, аяллын нөхцөл зэрэг үндсэн субьектив санааг бодитоор ойлгох харилцан ойлголт, харилцан зорчих хүсэл зорилго, хүмүүсийн

2 刘红霞.中蒙文化交流的优势与可拓展性.《对外传播》.2016年第01期,第54页.

3 中国新华网,习近平在韩国国立首尔大学的演讲(全文).2014.07.04. [http://www.xinhuanet.com/world/2014-07/04/c\\_1111468087.htm](http://www.xinhuanet.com/world/2014-07/04/c_1111468087.htm)

4 Хятадын олон улсын радио сайт, “У.Хүрэлсүх: Монгол, Хятад хоёр улс иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаагаа гүнзгийрүүлэн хөгжүүлэх өргөн боломж байна”. 2018.04.08. <http://mongol.cri.cn/news/hot/256/20180408/114701.html>

харилцаа солилцооны байдал, аяллын шаардлага зэрэг харилцан зорчих олон төрлийн бодит эрэлт хэрэгцээнд түшиглэн судалгаа шинжилгээ хийж, одоо байгаа аялал жуулчлалын орчны давуу болон сул талуудыг судалж, нөхцөл байдалд зохицуулсан арга

хэмжээг боловсруулж, шинжлэх ухааны үндэслэлтэй зүй зохистой холбогдох бодлогыг боловсруулан хэрэгжүүлснээр Монгол Улс, БНХАУ болон Өвөр Монголын хооронд аялал жуулчлалын таатай орчныг бүрдүүлэх юм.

## **Нэг. Монгол Улс ба Өвөр Монголын иргэд хоорондын харилцан аялах хүсэл сонирхлын өнөөгийн байдал**

*1.1 Аялал жуулчлалын хамтын ажиллагааг хөгжүүлэх олон нийтийн хүсэл сонирхол өндөр байна.* “Монгол Улс болон ӨМӨЗО-ны иргэд харилцан аялах тухай санал асуулга”<sup>5</sup> статистик судалгаагаар, аялах дуртай эсэх асуултад Өвөр Монголын иргэдийн 98.13% нь дуртай, 1.87% нь дургүй гэсэн бол Монгол Улсын иргэдийн 90.87% нь дуртай, 9.13% нь дургүй гэж илэрхийлсэн байна. Аялал жуулчлал бол улс орон, үндэстэн ястан, насны хязгаар хамаардаггүй бүх нийтийн үйл хэрэг юм. Монголын Үндэсний Статистикийн газрын мэдээлснээр, 2019 онд Монгол Улсад зорчсон Хятад улсын жуулчдын нийт тоо 169 000 хүрсэн нь БНХАУ Монгол Улсын аялал жуулчлалын зах зээлийг тэргүүлж буйг харуулж байна. Харин Монгол Улс нь Хятадын аялал жуулчлалын хамгийн том эх үүсвэрийн зах зээлийн долоодугаарт орно<sup>6</sup>. Монгол Улс нь Өвөр Монголын аялал жуулчлалын салбарын хамгийн том эх

үүсвэр бүхий орон болжээ. Статистик мэдээллээс харахад, 2018 онд Өвөр Монголын хилээр нэвтэрсэн Монгол Улсын жуулчдын тоо давхардсан тоогоор 950 000-д хүрсэн нь<sup>7</sup> Өвөр Монголд зорчсон нийт жуулчдын 50.5%-ийг эзэлж байна. Судалгаанаас үзэхэд, Монгол Улсаас Өвөр Монголд аялах дуртай иргэд ба Өвөр Монголоос Монгол Улсад аялах дуртай иргэдийн хувь тус бүр 72.41% болон 76.97%-ийг эзэлж байна. Үүнээс үзэхэд хоёр талын иргэдийн харилцан зорчих хүсэл сонирхол бэхжиж байна.

*1.2 Уламжлалт соёл ба түүхэн гарал үүсэл нь хоёр талын иргэд харилцан аялахын үндсэн элементүүд болж байна.* Статистик судалгааны дагуу Өвөр Монголын иргэдийн 76.97% Монгол Улсад аялах дуртай гэсэн бол 23.03% иргэд дургүй гэжээ. Үндэс ясаар бүртгэсэн бүртгэлээс үзэхэд, өвөрмонголчуудын дотор

5 Тус бүтээлд тодорхой заагаагүй “Судалгаанаас үзэхэд” гэдэг нь “Өвөр Монгол ба Монгол улсын иргэдийн харилцан аяллын зорилтын санал асуулга” судалгааны үр дүн ба статистикийн үр дүнг хэлнэ.

6 中国新闻网, “中国成蒙古国首要客源国”. 2019.08.16 <https://baijiahao.baidu.com/s?id=1641980896837311406&wfr=spider&for=pc>

7 中国内蒙古自治区统计局 (Өвөр Монголын Статистикийн газар), 内蒙古统计年鉴2019. <http://tj.nmg.gov.cn/Files/tjnj/2019/zk/indexch.htm>

Монгол Улсад аялах дуртай нь 87.18% эзлэж, 12.82% дургүй байна. Харин Хятад үндэстэн иргэдийн 68.26% Монгол Улсад аялах дуртай, 31.74% нь дургүй гэсэн бол бусад үндэстний 52.94% нь дуртай, 47.06% нь дургүй гэдгээ илэрхийлжээ. Монгол Улсад аялахад аялал жуулчлалын үзэсгэлэнт газруудыг сонгож байгаагаас үзэхэд, унаган байгалийн үзэсгэлэнт газрыг 80.59%, уламжлалт соёлын онцлогт газрыг 63.34%, түүхэн дурсгалт газрыг 61.46%-ийг тус тус сонгосон байна. Харин Өвөр Монголд зорчиж буй Монгол Улсын жуулчдын 57.7% нь уламжлалт соёлын онцлог бүхий газруудыг, 43.7% нь түүхэн дурсгалт газруудыг тус тус сонгосон байна. Үүнээс үзэхэд, Монгол Улс ба Өвөр Монголын хооронд түүхэн гарал үүсэл, уламжлалт соёл нь хоёр талын иргэдийн аялал жуулчлалын үндсэн нөөц элемент болж байна.

*1.3 Иргэд хоорондын харилцан зорчих явцад сэтгэл ханамжийн байдал ерөнхийдөө сайн байна.* Өвөр Монголын ард түмэн Монголын ард түмэнд найрсаг ханддаг эсэхийг тодруулсан судалгаанд Монгол Улсын иргэдийн 70.18% нь найрсаг, 29.82% нь найрсаг бус ханддаг хэмээн хариулжээ. Өвөр Монголд аялсан Монгол Улсын иргэд ерөнхийдөө сэтгэл хангалуун байдаг. Статистик судалгааны дагуу Монгол Улсын иргэд Өвөр Монголд аялахад сэтгэл ханамжгүй байдал нь эхлээд эрүүл ахуйн орчин, дараа нь хэлний бэрхшээлээс үүдэлтэй байдал, байр хоолны үнэ, орон нутгийн үйлчилгээний чанар, соёлын ялгаа,

бусад, орон нутгийн хүндэтгэлгүй байдал, зам тээврийн нөхцөл зэргээс шалтгаалж байна. Эдгээр нь тус бүр 57.29%, 28.13%, 25.52%, 11.98%, 10.42%, 9.9%, 7.81%, 6.25%-ийг эзэлж байна. Харин Монгол Улсын иргэд Өвөр Монголын иргэдэд нөхөрсөг, найрсаг байдаг эсэх талаар статистик үзүүлэлтээс харахад, Өвөр Монголын иргэдийн 83.85% нь нөхөрсөг, 16.15% нь нөхөрсөг бус хэмээжээ. Монгол Улсад аялсан Өвөр Монгол иргэдийн сэтгэл ханамж ерөнхийдөө өндөр байдаг ч сэтгэл хангалуун бус байдлыг нь жагсаавал, замын байдал, орон нутгийн анхаарал халамж, хүндэтгэл хангалтгүй, орон нутгийн үйлчилгээний чанар муу, бусад, соёлын ялгаанаас улбаатай хүндрэл, хэлний бэрхшээл, орон байр хоол хүнсний үнэ өртөг, эрүүл ахуйн шаардлага хангалтгүй зэрэг нь тус тус 60.34%, 22.41%, 18.87%, 17.24%, 17.24%, 12.07%, 10.34%, 5.17% -ийг эзэлж байна.

*1.4 Монгол Улс ба Өвөр Монголын иргэд харилцан зорчих зорилго нь аялах жуулчлах, ажил хөдөлмөр эрхлэх, суралцахаар гол болгосон байна.* Монгол Улсад (эсвэл Өвөр Монголд) очсон эсэх статистик мэдээллээс харахад, судалгаанд хамрагдсан Монгол Улсын иргэдийн 38.98% нь Өвөр Монголд, Өвөр Монгол иргэдийн 11.85% нь Монгол Улсад зорчсон байна. Аялал жуулчлалын зорилгын статистик мэдээллээс, Өвөр Монголын иргэд Монгол руу явах гол зорилго нь аялах жуулчлах, ажил хийх, суралцах, төрөл төрөгсөддөө айлчлах, худалдан

авалт хийх болон бусад зүйлүүд бөгөөд эдгээр нь тус тус 56.9%, 37.93%, 29.31%, 10.34%, 10.34%, 5.17%-ийг эзэлж байна. Монгол Улсын иргэд Өвөр Монгол руу явах гол зорилго нь аялах жуулчлах, ажил хийх, суралцах, худалдан авалт хийх, бусад, төрөл төрөгсөддөө очих зэрэг болно. Эдгээр нь тус тус 34.38%, 28.65%, 23.96%, 23.44%, 10.94%, 8.33%-ийг эзэлж байна. Үүнээс Монгол Улс болон Өвөр Монголын хооронд зорчиж буй иргэд гол төлөв аялах жуулчлах, дараа нь ажиллах, сурах чиглэлээр зорчиж байгаа бөгөөд ялимгүй ялгаа нь бараа худалдан авах хүмүүсийн эзлэх хувь нь Монгол Улсын иргэдэд бага зэрэг өндөр байна.

*1.5. Харилцан зорчих төвлөрсөн бүс нутаг нь гол төлөв* Өвөр Монголын төв Хөх хот, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот ба хил дамнасан бүс нутаг байна. Статистик судалгаагаар Өвөр Монголын иргэдийн хамгийн их зорчдог газар нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар бүс, дараа нь Зүүн бүсийн болон Төвийн бүс нутаг, Хангайн бүс, Баруун бүс болно. Эдгээр нь тус тус 77.59%, 41.38%, 31.03%, 24.14%, 13.79%-ийг эзэлж байна. Өвөр Монголын голлох аймаг хотуудад аялж буй Монгол Улсын иргэдийн эзлэх хувь нь Хөх хотод 70.31%, Шилийн гол аймагт 36.46%, Ордос хотод 25%, Бугат хотод 19.79%, Алашаа аймагт 14.58%, Улаанхад хотод 9.38%, Хөлөнбуйр хотод 6.77%, Үхай хотод 6.77%, Тунляо

хотод 6.25%, Хянган аймагт 4.17%, Баяннуур хотод 3.13%, Улаанцав хотод 2.08%-ийг тус бүр эзэлж байна.

*1.6. Монгол Улсын иргэдийн аялалд нөлөөлөх хамгийн чухал хүчин зүйл бол санхүүгийн боломж,* Өвөр Монгол иргэдийн аялалд нөлөөлж буй хамгийн чухал хүчин зүйл бол цаг хугацаа юм. Статистик судалгаагаар, Монгол Улсын иргэд жилд 3-аас их зорчдог нь 7.3%, 1-2 удаа аялдаг нь 36.11%, 1-ээс бага удаа байгаа нь 24.54% бол огт аялж байгаагүй иргэд 32.05%-ийг эзэлж байна. Өвөр Монголын иргэдийн аялах байдал нь жилд 3-аас дээш, 1-2 удаа, 1-ээс бага байгаа, огт аялаагүй иргэдийн эзлэх хувь нь тус тус 10.6%, 43.04%, 25.16%, 21.2% байна. Аялал жуулчлалын нөлөөлөх хүчин зүйлсийн статистик мэдээгээр, Өвөр Монголын иргэдийн аялахад нөлөөлдөг гол хүчин зүйл бол цаг хугацаа, бусад хүчин зүйлүүдийн дараалал нь санхүүгийн боломж, аяллын цэгийн жуулчдыг татах хэмжээ, орон зай болон бусад хүчин зүйл болно. Тэдгээр нь тус тус 73.85%, 59.57%, 33.69%, 23.45%, 8.36%-ийг эзэлдэг. Монгол Улсын иргэд аялахад нөлөөлж буй гол хүчин зүйл бол санхүүжилт бөгөөд бусад хүчин зүйлийг жагсаавал цаг хугацаа, үзвэрийн цэгийн анхаарал татахуйц байдал, орон зай болон бусад хүчин зүйл багтаж, тэдгээр нь тус тус 63.03%, 25.77%, 20.73%, 17.93%, 9.24%-ийг эзэлж байна.

## Хоёр. Хоёр талын иргэдийн харилцан аялах ба харилцан аялах хүсэл сонирхолд тулгамдаж буй асуудлууд

2.1 Аялал жуулчлалын орчны ерөнхий бүтээн байгуулалт хоцрогдонгүй, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх шаардлагатай.

2.1.1 Монгол Улсын зам тээвэр сайнгүй, Өвөр Монголын аялал жуулчлалын эрүүл ахуйн орчин тааруу. Жуулчдын хувьд цэвэр, эрүүл орчин, зам тээвэр сайн байх нь аялал жуулчлалын үйлчилгээний нэн тэргүүнд авч үзэх нөхцөл бөгөөд энэ нь аялал жуулчлалын үйлчилгээг стандартын дагуу байгуулах, аялал жуулчлалын зах зээлийн орчныг сайжруулах үндэс юм. Монгол Улсын Засгийн газраас аялал жуулчлалын салбараа эдийн засгийг хөгжүүлэх, гадаад валютын урсгалыг өсгөх, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, үндэсний бахархалыг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой төдийгүй хөрш зэргэлдээ ОХУ, БНХАУ-тай харилцан ойлголцол, хамтын ажиллагааг өргөжүүлэх голлох салбарын нэг мөн <sup>8</sup> гэж заажээ. Гэвч өнөөгийн байдлаар Монгол Улсын дэд бүтцийн бүтээн байгуулалт өөр хоорондоо уялдаагүй, зам нь хуучирсан тул өөрийн хөгжлийн хэрэгцээг хангах чадваргүй байгаа нь бүх төрлийн салбарыг хурдацтай хөгжихөд ихээхэн хязгаарлаж байна. Статистик судалгааны мэдээллээс харахад, Өвөр Монголын зорчигчид Монгол Улсад зорчиход хамгийн сэтгэл ханамжгүй

зүйл нь зам тээврийн нөхцөл байдал гэсэн нь 60.34%-ийг эзэлж байна. Өвөр Монголд зорчсон монголчуудын хамгийн сэтгэл ханамжгүй зүйл бол ариун цэврийн орчин, энэ нь 57.29%-ийг эзэлжээ. Бидний мэдэж буйгаар, Өвөр Монгол болон Хятад даяар олон нийтийн эрүүл ахуйн орчин муу хэвээр байна. Жуулчид хаа сайгүй хог хаях, ариун цэврийн байгууламж хангалтгүй, буудал үзвэрийн цэг, хотын нийтийн бие засах газар цэвэр бус, цаг тухайд нь цэвэрлэдэггүй, жижиг, дунд хоолны газрууд ариун цэврийн шаардлага хангаагүй байдаг зэрэг олон шалтгааны улмаас аялал жуулчлалын нийтлэг орчин муу байгааг тус судалгааны үр дүн дахин нотолж байгаа бөгөөд үүнийг сайжруулах шаардлагатай.

2.1.2 Өвөр Монгол нь Монгол Улсын жуулчдад хэлний үйлчилгээ ба байр хоолны үнийн талаар илүү ээлтэй болох шаардлагатай. Аялал жуулчлалын салбар нь хүмүүсийг аялуулж, жуулчлуулах үйлчилгээний салбар юм. Үйлчлэх явцад үйлчилгээний объектын хэрэгцээ, онцлог байдлын талаарх ойлголтыг шаарддаг. Өвөр Монгол руу аялж буй монголчууд хэлний бэрхшээлтэй тулгардаг, тэдний онцлог нь хэрэглээний түвшин тийм ч өндөр биш байдаг нь аялал жуулчлалыг түшиглэн иргэдийн ойлголцлыг ахиулахад нэн

8 Л.Оюунчимэг, Н.Гантуяа. Монголд аялж буй Хятадын жуулчдын аяллын зан төлөвийн судалгаа. 2019 оны Монгол, Хятад, Оросын Тинк Танкийн олон улсын форумын өгүүллийн түүвэр. (中蒙俄智库国际论坛报告 2019) .

тэргүүнд анхаарах ёстой практик асуудал юм. Одоогоор Өвөр Монголын зарим үйлчилгээний газар, зочид буудал, аялал жуулчлалын газруудад монгол хэлний үйлчилгээ хараахан түгээмэл болоогүй байна. Үүнээс гадна гадаадын зочдыг хүлээн авах тусгай зөвшөөрөлтэй зочид буудлын үнэ харьцангуй өндөр байгаа нь Монгол Улсын жирийн жуулчдад хүндрэл үүсгэдэг байна. Статистик мэдээллээр Монгол Улсын жуулчдын 25.52% нь Өвөр Монголын зочид буудал, хоол хүнсний үнэ өртөгт сэтгэл хангалуун бус байна.

2.2 Хоёр талын нийгмийн аюулгүй байдлын асуудал нь хүмүүсийн харилцан зорчихыг хязгаарлах хүчин зүйл болж байна. Аяллын аюулгүй байдал нь аялал жуулчлалын хөгжлийн үндсэн баталгаа хийгээд аялал жуулчлалын амин судас, аж үйлдвэрийн хөгжлийн гол цөм юм. Аялал жуулчлал эрчимтэй хөгжихийн зэрэгцээ аялал жуулчлалын аюулгүй байдлын асуудал бодитоор ноцтой болжээ. Статистик мэдээллээс харахад, Өвөр Монголын иргэдийн 23.03% нь Монголд очихыг хүсэхгүй байгаагаа илэрхийлсэн бөгөөд тэдний 34.23% нь аюулгүй байдлын талаар эрсдэлтэй гэжээ. Мөн Өвөр Монголд ирэхийг

хүсээгүй Монгол Улсын иргэдийн 38.97% нь аюулгүй байдлын болзошгүй аюулыг бодолцож буй хэрэг юм. Үүнээс үзэхэд хоёр талын иргэдийн харилцан зорчихыг хязгаарласан нэг хүчин зүйл бол нийгмийн аюулгүй байдлын баталгаа болох нь тодорхой харагдаж байна.

2.3 Хоёр талын иргэдийн харилцан ойлголцол хангалтгүй. Статистик судалгааны мэдээллээс харахад Өвөр Монгол иргэдийн 45.02% нь Монгол Улсын талаар огт мэдэхгүй байна. Харин Монгол Улсын иргэдийн 33.47% нь Өвөр Монголын талаар тодорхой мэдээлэлгүй байна. Хоёр талын бие биеэ ойлголцох арга зам нь цахим сүлжээ, телевизийн нэвтрүүлэг, найз нөхдийн танилцуулга зэрэг л болж байна. Үүнээс Өвөр Монгол, Монгол Улс нь ойрын хөрш, бас ижил төстэй гарал үүсэлтэй хүмүүс байгаа боловч бие биеийнхээ талаархи ойлголт ихээхэн дутагдаж байгаа нь харагдаж байна. Харилцан ойлголцох арга замын хувьд, цахим сүлжээ нь олон төрлийн худал хуурмаг мэдээллийг хэт их агуулж, хандалтыг нэмэгдүүлэх зорилгоор кейс судалгааг өдөр тутмын мэдээ, мэдээлэл болгон цацаж буй үзэгдэл оршиж байна.

## Гурав. Иргэдийн харилцан аялах хамтын ажиллагааг ахиулах санал зөвлөмж

3.1 Хоёр талын “Соёл+Аялал жуулчлал” хамтын ажиллагаа ба сурталчилгааг эрчимжүүлж, Монгол, Хятадын иргэдийн ойлголцлыг ахиулах.

*3.1.1 Хоёр талын түүх соёлын дурсгалт газраар аялах хамтын ажиллагааг өрнүүлэх.* Статистик мэдээллээс харахад, Монгол Улсын иргэд Өвөр Монголд аялахдаа голдуу түүхэн дурсгалт газруудыг сонгодог бөгөөд түүний эзлэх хэмжээ нь 57.7% байдаг нь хамгийн өндөр үзүүлэлт юм. Үүнтэй адилаар Монгол Улс руу аялж буй Өвөр Монголын иргэдийн 61.46% нь мөн түүхэн дурсгалт газруудыг сонгосон байна. Монгол Улс болон Өвөр Монголын өнө удаан түүхэн замнал, түүхэн явцад хоёр тал түүх, соёлын дурсгалт газруудыг олноор үлдээсэн нь бие биеийнхээ өнгөрсөн түүхийг гэрчилж байна. Жишээ нь, Өвөр Монголын Хар хотын туурь, Их Юан улсын дээд нийслэлийн туурь, Торгоны замын төв-Юан гүрний Жинин замын эртний хотын туурь гэх мэт. Үүний зэрэгцээ, Өвөр Монгол бол соёлын чухал дурсгалт газрууд тархсан, өв соёлын өргөн уудам газар нутаг юм. Тухайлбал Шинлунва (兴隆洼) буурь, Хамбын манхан (哈民忙哈) эртний хүний амьдарч байсан бууц, Киданы Ляо улсын дээд нийслэлийн туурь зэрэг байдаг. Монгол Хятадын түүх соёлыг гэрчлэх

эдгээр дурсгалт газрууд нь Монгол Улс ба Өвөр Монголын аялал жуулчлалын хамтын ажиллагаа, солилцооны чухал үндэс суурь юм.

*3.1.2 Монгол уламжлалт соёлыг гол сэдэв болгосон аялал жуулчлалын хамтын ажиллагааг өрнүүлэх.* Соёл нь тухайн үндэстний аж төрөх ёс, бас нийхэм. Энэ талаасаа, соёл бол тухайн орны иргэдийн гадаад орчиндоо, бусад хүмүүстэйгээ зохицон аж төрөхөд чиглэгдсэн янз бүрийн аргуудын (эрдмүүдийн), бас үйлдэх тэмдгүүдийн (бичиг үсгийн) багц юм<sup>9</sup>. “Бүс ба Зам” бүтээн байгуулалтыг урагшлуулахад Өвөр Монгол нь газарзүйн, боомтын, хүмүүнлэг соёлын давуу талаа түшиглэн Монгол, Хятадын хооронд соёлын солилцооны гүүр болж, түүний хил дамнансан угсаатан иргэд нь Монгол, Хятадын хооронд соёлын солилцооны элч болж, Монгол үндэстний уламжлалт соёл нь иргэдийн сэтгэлийг нээх түлхүүр болж байна. Иймээс Монгол Улс болон Өвөр Монгол соёлынхоо онцлогийг тодотгож, Монгол уламжлалт соёлыг гол сэдэв болгон аялал жуулчлалын хамтын ажиллагааг өрнүүлж, хоёр талын нийгмийн түүх, соёлын хүрээнд өөр өөр хэлбэрээр буй болсон ёс заншил, зан төлөв, сэтгэлгээ, үнэ цэнийн тухай ойлголт зэргийн ялгаатай талыг чухалчлан авч үзэж, хоёр орны иргэд бие биенээ гүнзгий таньж

9 Б.Жадамбаа. Язгуур суртахуун – хамтын ажиллагааны үндэс. “Монгол, Хятад, Оросын олон улсын эрдэмтдийн Тинк Танк форум – 2016” өгүүллэйн эмхэтгэл. Хятадын хөгжил хэвлэлийн хороо, 2019, тал 368.

мэдэн, шаардлагагүй буруу зөрүү ойлголт, элдэв зөрчлийг арилгаснаар иргэд хоорондын нийтлэг ойлголцолд бодитоор хүрэх болно.

3.2 Харилцан аялах орчны аюулгүйн баталгааг бэхжүүлж, харилцан зорчиход үүсч болзошгүй эрсдэлийг бууруулах шаардлагатай.

3.2.1 *Жуулчдын хувийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог* боловсронгуй болгохыг санал болгож байна. Монгол, Хятад хоёр улс нь харилцан жуулчлалын чухал эх үүсвэр, чиглэлийн зорилгот орон болж буйн хувьд, хоёр орны хоорондох иргэдийн солилцоо нэмэгдэхийн хэрээр төр засгаас баталсан гадаадын жуулчдын аюулгүй байдлын баталгааны тогтолцооноос гадна талууд Монгол, Хятад иргэдийн харилцан зорчих аюулгүй байдлын баталгааны тогтолцоог боловсруулж, иргэдийг харилцан зорчих үед биеийн болон эд хөрөнгийн аюулгүй байдлыг хамгаалах, жуулчдыг сэтгэл тайван амар амгалан харилцан зорчих чиглэл маршрутыг гаргаж, иргэд хоорондын харилцан итгэлцэл, нөхөрлөлийг нэмэгдүүлэх боломжийг олгох хэрэгтэй байна.

3.2.2 *Монгол, Хятадын гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдлын асуудлыг хамтран шийдэх гомдол хүлээн авах цэгийг хамтран байгуулахыг санал болгож байна.* Судалгаанаас үзэхэд, аялж жуулчлах явцдаа Монгол, Хятадын жуулчид гэнэтийн буюу онцгой нөхцөл байдалд

бие болон эд хөрөнгийн халдлагад өртөж, хохирол учирсан тохиолдолд тэвчээр зааж, маш цөөн хүн хэргийн талаар цагдаад эсвэл элчин сайдын яаманд мэдэгддэг ажээ. Асуудлын гол нь хэргийг шийдэх журам нь нарийн төвөгтэй, хэтэрхий их цаг хугацаа шаардагддаг гэж харагдаж байна. Энэ нь гэмт хэрэгтнүүдийн дураараа аашлах үйлдлийг өдөөгөөд зогсохгүй олон жуулчдыг аялж, зорчихоос татгалзахад хүргэж байна. Иймд энэхүү бодит нөхцөл байдлыг харгалзан иргэдийн гадаадад тохиолдож байсан ослыг тодорхой шийдвэрлэж, ажлын үр ашгийг дээшлүүлэх зорилгоор Монгол, Хятадын гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдлын асуудлыг хамтран шийдэх гомдол хүлээн авах цэг байгуулах санал дэвшүүлж байна.

3.3 Мэдээллийн солилцооны механизмыг байгуулж, орон нутгийн засаг захиргаа, аялал жуулчлалын байгууллага зэргийн хамтын ажиллагааг эрчимжүүлж, жуулчдын хүсэл зорилгыг цаг тухайд нь ойлгох.

3.3.1 *Орон нутгийн засаг захиргаа ба аж ахуйн нэгжийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай.* Монгол, Хятад хоёр улсын Засгийн газар “Монгол, Хятадын хил дамнасан аялал жуулчлалын хамтын ажиллагааны бүсийн мастер төлөвлөгөө” зэргийг үндэслэн, бүх бүс нутагт аялал жуулчлалын жишиг бүсийг байгуулахаар зорьж, Монгол Хятадын хил дамнасан аялал жуулчлалын хамтын ажиллагааны бүс ба хилийн

аялал жуулчлалын туршилтын бүсийг гол болгож, хилийн аялал жуулчлалын хөгжлийг бүх талаар удирдлага болгон хөгжүүлнэ. Талууд харилцан зөвшилцөж аялал жуулчлалын хамтын ажиллагааны жишиг бүсийг тодорхойлж, хоёр талын аялал жуулчлалын нөөц байдалд түшиглэж, Засгийн газрын түвшинд гэрээ байгуулж, хамтын ажиллагааны эрчимтэй хөгжлийг хангахын тулд хамтын ажиллагааны гол чиглэлүүдийг тодорхойлох хэрэгтэй.

*3.3.2 Жуулчдын санал гомдлыг цаг тухайд нь ойлгох механизмыг бүрдүүлэх, тухайн цагт нь аялал жуулчлалын хамтын ажиллагааны холбогдох тогтолцоог төгөлдөржүүлэх хэрэгтэй.* Монгол Улс болон Өвөр Монголын аялал жуулчлалын хамтын ажиллагааны гол зорилго нь эдийн засгийн өсөлтийн цэг болохоос гадна хоёр орны ард түмний хоорондын харилцан ойлголцлыг сайжруулж, иргэд хоорондын найрамдал нөхөрлөлийг бэхжүүлж, Монгол, Хятадын соёлын солилцоонд Өвөр Монгол нь гүүрийн үүргийг гүйцэтгэхэд оршино. Иймээс жуулчдын санал гомдлыг цаг тухайд нь ойлгох механизмыг бүрдүүлж, харилцан зорчих иргэдийн саналд тулгуурласан аялал жуулчлалын хамтын ажиллагааны бодлогыг тогтмол сайжруулах үндсэн дээр аялал жуулчлалыг ардын дипломат харилцаа болгож, иргэд хоорондын ойлголцолд хүрэх асуудлыг бодитоор хэрэгжүүлнэ.

3.4. Харилцан аялах газрыг төгөлдөржүүлж, Монгол Улс ба Өвөр Монголын иргэдийн бодит эрэлт хэрэгцээнд тохирсон аялал жуулчлалын чиглэлийг байгуулах

*3.4.1 Зам тээврийн дэд бүтэц ба эрүүл ахуйн орчны бүтээн байгуулалтыг түргэсгэх.* Монгол Улсын зам тээвэр дэд бүтцийн хөгжил сул дорой буй асуудлын талаар Монгол, Хятад, Орос гурван талын байгуулсан “Монгол, Хятад, Оросын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-тэй Монгол, Хятадтай холбоотой зам тээврийн дэд бүтцийн төслүүдэд холбогдох яам байгууллагууд идэвхтэй уялдуулан ажиллаж, “Монгол, Хятад, Оросын эдийн засгийн коридор”-ын зам тээврийн дэд бүтцийн бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх механизмыг бий болгож, түүнийг хурдацтай үр дүнтэй хэрэгжүүлснээр Монгол Улсын аялал жуулчлалын зам тээврийн асуудлыг шийдвэрлэж болно. Монгол Улсад хуралдсан “Аялал жуулчлалын судалгаа-2018” эрдэм шинжилгээний бага хурлын үеэр БОАЖЯ-ны АЖБЗГ-ын даргын үүрэг гүйцэтгэгч С.Баясгалан “Монгол Улс өргөн уудам газар нутагтай тул жуулчин ганц, хоёр чиглэлд явдаггүй. Тэр бүх газруудын дэд бүтцийг хөгжүүлнэ гэдэг асар хүндрэлтэй тул аль болох жуулчид ихээр явж байгаа газруудаа тогтоогоод тухайн газруудад нэн тэргүүнд бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлье, дэд бүтцийг нь бий болгоё гэх зорилтын хүрээнд бодлогын баримт бичгийг баталсан”<sup>10</sup> хэмээн онцолж

10 Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яамны сайт. “Аялал жуулчлалын судалгаа-2018” эрдэм шинжилгээний хурал боллоо. 2018.11.30. <https://www.mne.mn/?p=6800>

байв.

Мөн тус судалгааны дагуу үүнтэй уялдуулан нэн тэрүүнд Монголын ард түмэн, жуулчдын хамгийн их төвлөрсөн газар болох нийслэл Улаанбаатар хотод тусламжийн шугамаар автозам барих санал дэвшүүлж байна. Өвөр Монголын аялал жуулчлалын эрүүл ахуйн орчин муу зэрэг асуудлын хувьд, Өвөр Монголын аялал жуулчлалын орчныг бүрдүүлэхдээ нэгбүрчлэн анхаарч, аялал жуулчлалын байгууламжийг сайжруулах, эрүүл ахуйн байгууламж, хяналтын тогтолцоог бүх шугамаар сайжруулах, аялал жуулчлалын орчин муугаас үүдэн гарах сөрөг нөлөөллийг бууруулах буюу арилгах хэрэгтэй байна.

*3.4.2 Монгол, Хятадын соёлын харилцааны хамтын ажиллагаанд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, Монгол Улсын нийт иргэдэд Өвөр Монголд аялахад хүртээмжтэй байх талыг өргөжүүлэх. Өвөр Монголд аялж буй Монгол Улсын иргэдийн зарлагын түвшин өндөр биш зэрэг бодит байдалд холбогдох дэмжлэгийг үзүүлэх. Тухайлбал, зочид буудалд байрлах зардлын тодорхой хэсгийг Засгийн газраас Монгол Улсад соёлын хөрөнгө оруулах зорилгоор татаас хэлбэрээр авах, сүм хийд, хөшөө дурсгалын газрын тасалбарыг чөлөөлөх гэх мэт арга хэмжээ авах, зочид буудал, аялал жуулчлалын дурсгалт газруудын үзвэрүүдийн тасалбар үнэтэй байх зэрэг Монгол Улсын иргэдэд тулгамдаж буй асуудлыг бодитоор шийдэж, бие биенээ илүү ойлгож,*

хамтдаа илүү сайн орчин нөхцлийг бүрдүүлэх нь чухал юм.

*3.4.3. Монгол Улс болон Өвөр Монголын харилцан зорчих аялал жуулчлал + худалдан авалтын нэрийн чиглэл маршрутыг бий болгох. Монгол Улсын ихэнх иргэд Өвөр Монголд өдөр тутмын хэрэгцээт зүйлсээ худалдаж авахаар зорчдог бол Өвөр Монголын иргэд Монголоос ноолуур, арьс шир зэрэг Монголын тусгай бүтээгдэхүүнийг худалдан авах сонирхолтой байдаг. Энэ бодит байдалд тулгуурлан, аялал жуулчлал + худалдан авалтын чиглэл маршрутыг буй болгох чиглэлээр хоёр тал хамтран ажиллах боломжтой. Алашаа, Баяннуур, Бугат, Улаанцав, Шилийнгол, Хянган, Хөлөнбуйр зэрэг аймаг хотын газарзүйн болон боомтын давуу талыг бүрэн ашиглаж, аялал жуулчлалын хамтын ажиллагааны туршилтын цэгийг Монгол Улстай зэргэлдээ төв болон зүүн бүсийн нутагтай хамтран аялал жуулчлалын чиглэл маршрутыг “худалдан авах + аялж жуулчлах” хэлбэрээр гаргаж, хоёрдогч зорилгоор нь бүх холбоосыг стандартчилах, хоёр талын эдийн засаг, худалдааны солилцоог сайжруулах, эдийн засгийн орлогыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ зарим нэг хөндлөнгөөс оролцох шударга бус худалдаачдыг цөөрүүлэх хэрэгтэй. Чингэснээр жуулчдыг халуун дулаан, тав тухтай, түргэн шуурхай, эрүүл ахуйн шаардлага хангасан нийтийн үйлчилгээний нөхцөлөөр хангах болно.*

Ашигласан материал

- 杨辉. 民心相通“一带一路”建设的社会根基. 经济日报出版社, 2017年.
- 刘丽梅. 中蒙俄旅游合作及其发展策略研究[J]. 内蒙古: 内蒙古财经大学学报, 2016.
- Ч.Мөнхжаргал. “Соёлын аялал жуулчлал”, Улаанбаатар, 2017 он.
- 杜丽岩, 冰清. 中蒙两国旅游交流现状及意义分析[J]. 北京: 前沿理论, 2018.
- Н.Эрдэнэ-Очир. “Монгол орны түүх, археологи, байгалийн дурсгалын аялал жуулчлалын үндсэн маршрут”, Улаанбаатар, 2018 он.
- 中国新闻网, “中国成蒙古国首要客源国”. 2019. 08. 16. <https://baijiahao.baidu.com/s?id=1641980896837311406&wfr=spider&for=pc>
- 中国内蒙古自治区统计局 (Өвөр Монголын Статистикийн газар), 内蒙古统计年鉴2019. <http://tj.nmg.gov.cn/Files/tjnj/2019/zk/indexch.htm>
- 中蒙俄智库国际论坛报告(2015). 内蒙古自治区发展研究中心. 中国发展出版社, 2020年.
- 中蒙俄智库国际论坛报告(2016). 内蒙古自治区发展研究中心. 中国发展出版社, 2019年.
- 中蒙俄智库国际论坛报告(2019). 内蒙古自治区发展研究中心. 中国发展出版社, 2020年.
- Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яамны сайт, “Аялал жуулчлалын судалгаа-2018” эрдэм шинжилгээний хурал боллоо. 2018.11.30. <https://www.mne.mn/?p=6800>
- 张秀杰. 中蒙旅游合作及其发展策略研究. 俄罗斯中亚东欧市场. 2011年第6期.
- 郭业洲等. “一带一路”民心相通报告. 人民出版社, 2018年.
- 中蒙关系研究编委会. 中蒙关系研究(一). 内蒙古大学出版社, 2015年.
- 刘红霞. 中蒙文化交流的优势与可拓展性. [J]《对外传播》. 2016年第01期.
- 海伦. 蒙古国与中国内蒙古旅游合作研究[D]. 内蒙古: 内蒙古大学, 2016.

## Research on strengthening people-to-people ties between Mongolia and Inner Mongolia through tourism

— Based on *Survey on Mongolian People's Intention Travelling to Inner Mongolia* and *Survey on Inner Mongolia Autonomous Region People's Intention Travelling to Mongolia*

Mao Yanli

Research Officer, Ph.D

Research Institute of China-Russia-Mongolia cooperation, Inner Mongolia Autonomous Region, China

Email: 1915795638@qq.com

**Abstract:** It's widely known that there exist diversities and common ground in cultural identification between China and Mongolia. In recent years, Inner Mongolia serves as a bridge for promoting cultural exchanges between two sides. Hence, a series of diversified relevant activities have been implemented in education, medicine, tourism, arts etc., of which tourism is a key area. Accordingly, this paper researches on the current situation of bilateral travel between two sides through questionnaire survey, case analysis and correlative references, discovering existing problems and offering countermeasures and suggestions. The research aims to build a tourism cooperation environment between two sides in an approachable and reasonable way to meet the demands of tourists from two countries. Meanwhile, promoting exchanges, co-construction, communication and mutual trust in order to further strengthen people-to-people ties between two sides. Thus, solid public support for development and cooperation between China and Mongolia will be achieved.

**Keywords:** Inner Mongolia, Mongolia, people's bilateral travel intention between Mongolia and Inner Mongolia

<i>The day of submission:</i>	2020.4.8
<i>Completion of review:</i>	2020.5.1
<i>Final decision for acceptance:</i>	2020.5.8